

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

СЭТГҮҮЛ ЗҮЙН ХИЧЭЭЛИЙГ СОНИРХОЛТОЙ ЗААХ АРГА ЗҮЙН
АСУУДАЛД

Д.Батжаргал*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Утга зохиол, урлаг судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор

Түлхүүр үг: сургалтын шинэ арга хэлбэр, оюутны сэдэл, тэмүүлэл, сэтгүүл зүйнхичээлийг сонирхолтой явуулах арга, сэтгүүл зүйн үйл явцын хэлбэрүүд

Оюутнууд сургалтын шинэ арга хэлбэрт дуртай. Лекц, семинар, дадлагын ажил нь эл дол болсон хуучин арга барил, ном сурах бичгийг ямар нэгэн тайлбар, сонирхолтой өөрчлөлт, хувирал, “үсрэлт”, “тэсрэлт” үгүйгээр чанга дуугаар уншин, оюутнууд “ба бэ”-гүй хуулан бичдэг, “ном хувилдаг” аргаас залхаж байна. Шинэ зуун гарч, техник, технологийн хөгжил дэвшил нь сонирхолтой аргаар хичээл заах, суралцагчдыг уйдаахгүй, хөл хөөр, хөгжөөн цэнгээн баясалтайгаар суралцах, өрсөлдөх, мэтгэлцэх явц дунд мэдлэг олж авах боломжтой хэмээн үзэж байна.

Сэтгүүл зүй амьд организм. Үйл явдал нь одоо цаг дээр өрнөж байдаг болохоор сонирхолтой сургалт явуулж, оюутнуудад өгөөжтэй, шавь төвт оролцоотой хичээл заах илүү өргөн боломжтой. Данийн вант улсын Аорхусын сэтгүүл зүйн сургууль, АНУ-

ын Миссурийн их сургуульд хэрэглэдэг шинэлэг аргууд нь амьдрал, сургалт хоёрыг ойртуулан, дадлага практикийг илүү чухалчлан үздэг юм билээ. Энэ талаар “Сэтгүүлч” сэтгүүлд өмнө бичсэнээ сөхье.

“Оюутнууд өглөө орж ирээд өдөр тутмын сонин гарчиглан хоорондоо зөвлөлдөнө. Зарим нь өөрсдөө олж ирсэн санаагаа хөгжүүлэн ярилцана. Багш нь дуугүй, ажиглаж сууна. Санал зөрж маргалдах үед багш ганц хоёр үг хэлж маргаан таслана. Зарим нь санаагаа хамгаалан чармайх авч багшийн нотолгоог сонсоод чимээгүй болно. Иймэрхүү байдлаар шуурхай зөвлөлдөөн 20 минут үргэлжлээд тарав. Аппаратаа шүүрэн гадагшаа гарах нь гадагшаа гарч, интернетээс мэдээ хайх нь компьютер луу “шигдэцгээнэ”. Бэлтгэсэн хөтөлбөрөө 11 цагт эфирт цацаж сонсогчдод хүргэх учраас зарим зүйлийг тодруулан утсаар ярьж, материалаа бичин, редактортаа үзүүлж завгүй гүйлдэнэ. Бидний хэвшиж дадсан ойлголтоор хичээл биш, радиогийн мэдээний редакцийн нэг өглөөний дүр зураг харагдана. Энэ бол Данийн Вант Улсын сэтгүүл зүйн сургуулийн гу-

равдугаар дамжааны оюутнууд радио сэтгүүл зүйн хичээлээ хийж байгаа нь энэ. Хийнгээ суралцах аргаар сургалт явуулж байна”¹.

Сүүлийн үед сэтгүүл зүйн сургалтууд ийм л болж байна. Энэ ч бас саяхны баримт биш. Одоо бүр их өөрчлөгдөж байгаа. Ер нь өрнөдийн сэтгүүл зүйн зарим сургууль дэргэдээ оюутны сонин, телевиз, радио, цахим сайттай. Миссурийн сургууль гэхэд дэргэдээ “Кому” хэмээх телевизтэй, онлайн хувилбартай, дээр дурьдсан Данийн сургууль сонин, радиотой байх жишээтэй. Манай сэтгүүл зүйн сургуулиуд ядаж цахим сайттай, түүнийгээ оюутнуудын хүчээр “хөдөлгөөд” байх боломжтой. Сэтгүүл зүйн багш нар гэж чадалтай бичгийн түшмэд, хянан найруулагчид байна. Өрнөдийн сэтгүүл зүйн сургуулиудын жишгээр манайд хэрэглэж болох, зарим сургалтад мэр сэр хэрэглэж байгаа цөөхөн жишээ өгүүлье.

Хэвлэлийн бага хурал. Зочин багшийг сонирхолтойхэлбэрээр урих арга. Бакалаврын түвшний оюутнуудыг туршлагатай сэтгүүлчидтэй уулзуулаж гэвэл энэ аргыг ашиглаж болно. Жишээ нь, сэтгүүлч Д.Цэдэн-Иштэй уулзуулахын тулд түүний сүүлийн хоёр, гурван жилийн дотор бичсэн “Босго тэнгэрийн даваа Бурхан Халдун”, “Монгол хүний толгой дээр нар жаргадаггүй”, “Их Хятадууд нэгдэж хөгжөөд л, талын Монголчууд бид тарж сарниад л”, “Цагаан сар ба Ногоон Япон”, “Төлөг, хужаа л гэх юм. Бид өөрсдөө хэн юм бэ?”, “Хоёр ертөнцийн зураач”, “Энд ч, тэнд ч чиний шүлэг, дуунууд мөнх эгшиглэг дээ” зэрэг бүтээлүүдийг урьдчилан өгч уншуулна. Оюутнууд бүтээлүүдийг нь уншсан, бас “Ардын эрх”, “Өнөөдөр” зэрэг өдөр тутмын

томоохон сонин, ОНРТВ, Хэвлэлийн хүрээлэн зэрэгхэвлэл мэдээллийн халуун тогоонд чамгүй олон жил “чанагдаж”, нэрт сэтгүүлч Соёлын гавьяат зүтгэлтэн Б.Лигдэн, Ц.Балдорж, Б.Пүрэвдаш нартай гар нийлэн ажиллаж байсныг мэдсэн болохоор өөр өөрсдийн ярилцлага хийх, хөрөг бичих өнцгийн дагуу судалгаа явуулж, Б.Пүрэвдаш, Б.Лигдэн болон “Ардын эрх”, “Өнөөдөр” сонины сэтгүүлчдээс мэдээлэл авах боломжтой. Энэ нь судалгаа хийх боломжийг тэдэнд бэлэн өгч өөрсдөө авхаалж самбаа гарган сонирхолтой ярилцлага хийх нөхцлийг олгож байна.

АХА. Энэарга нь сэтгүүл зүйн түүх, сэтгүүл зүйн онол дадлага, сэтгүүл зүйн удиртгал, радио сэтгүүл зүй, телевизийн сэтгүүл зүй зэрэг хичээлүүдэд ашиглахад илүү тохиромжтой. АХА нь асуулт- хариулт-асуулт гэсэн ТВ-ийн танин мэдэхүйн тэмцээний хэлбэр. Ихэвчлэн ЕБС-ийн сурагчид оюутан залуус оролцдог. Сэтгүүл зүйн түүхийн нэгэн багц сэдвийг судалсны дараа оюутнууд холбогдох ном зохиол уншиж хүн бүр нэг сэдэвт 5-10 асуулт бэлтгэн, баг дотроо нэгтгэн бусад багийнхаасаа асууна.

- ✚ 1895 онд “Дорнод хязгаарын амьдрал” сониныг хаана гаргаж эхэлсэн вэ? /Чита/
- ✚ Алив нэгэн юмны “тухай” гэж эсс-гээ бичдэг Францын их сэтгэгч? /М.Монтень/
- ✚ Уламжлах мэдээлэх гэсэн латин үгнээс гаралтай сэтгүүл зүйн төрөл юу вэ? /Сурвалжлага/
- ✚ “Өнөөдрийн Монгол” сонины сэтгүүлч Модунь Шанью хаантай ярилцсан байдаг. Энэ ямар хэлбэрийн ярилцлага вэ? /Эчнээ ярилцлага/ гэх мэт.

АСТ арга. Дал наяд онд их дээд сургууль, ЕБС, албан байгууллагуудын дунд явагддаг хөгжөөнт тэмцээний нэг хэлбэр. “Авхаалж сэргэлэнчүүдийн тэмцээн” гэсэн үгийн товчлол. Оюутнууд хоёр багт хуваагдана. Баг бүр нэртэй, бас өөр өөрийн тодорхой хөгжөөн дэмжигчидтэй байна. Жишээ нь, “Чадвар”, “Лидер” гэсэн хоёр баг оролцож байна гэж бодъё. Багууд бие биедээ болон шүүгчид, хөгжөөн дэмжигчдэд зориулан мэндчилгээ дэвшүүлж болно. Ер нь хичээлийн нөхцөл боломжоос шалтгаалаад дүрмээ өөрсдөө зохиож өөрчлөх боломжтой. Мэндчилгээ нь үр дүн багатай шүлэглэсэн хуучин хэлбэр байх шаардлагагүй. “5W 1H” нэртэй мэндчилгээ дэвшүүлж болно. Тэгвэл асуулт бүр тохирсон мэндийн үгтэй байна. Жишээ нь, Who-Би бол үйлийн эзэн, What-Намайг танихгүй нэг ч хүн байхгүй, When- Цаг хугацаанаас чухал юм юу байдаг вэ, Where- Хаана гэдгийг хэлэхгүй бол хамгийн том алдаа, Why-Миний учрыг зөв олж явбал болно доо. Н- Аргыг мартаж болно гэж үү гэх мэтээр мэндчилгээ дэвшүүлж болно. Нөгөө баг нь “Монголын нийтлэлийн уламжлал” мэндчилгээ дэвшүүлвэл дохио мэдээ, юм мэдээ, зураг мэдээ, тамга мэдээ, ам мэдээ, элч мэдээ гэх мэтээр тус бүрийн онцлогт тохирсон үг өгүүлбэр хэлж болно. Энэ мэтээр багийн ахлагчийн асуулт, бие биедээ тавих асуулт хариулт, хөгжөөнт номер, урлагийн үзүүлбэр бүхнийг сэтгүүл зүйн хичээлтэйгээ холбож болно. “Практик сэтгүүл зүй”, “Сэтгүүлчийн ур чадвар” зэрэг хичээлийг сонирхолтой заах, оюутны мэдлэг дүгнэх, багаар ажиллах чадварыг үнэлэхэд илүү тохиромжтой.

“Яг түүн шиг” “Сонины менежментийн эцэг” гэгддэг Жозеф Пулитцер, “Мэдээллийн дайныг өдөөгч” Хёрст, “Ларри Кинг шууд дамжуулж байна” шоуны эзэн, “Дэлхийг өөрчилсөн 13 эмэгтэйн нэг” Опра Уинфра нарын дэлхийн ХМХ-ийн ассуудыг дууриан үзүүлж болно. Оюутнууд хөгжөөнтэй, зугаатай зүйлд дуртай. Зузаан нүдний шил зүүж, татуургатай өмдөөр гангардаг Ларри Кингийг дууриах оюутан дорхноо гараад ирнэ. Хамгийн гол нь гадаад өнгө төрхөөс илүү, хүний дотоод мөн чанарын илэрхийлэм асуулт тавьдаг бэлтгэдэг арга барилыг нь судална. Заавал гадаадын одод биш, сэтгүүлч Ш.Гүрбазарын “Та хариулахгүй ч байж болно”, З.Алтайгийн “Үүргэвчтэй аялал”, Л.Мөнхбаясгалангийн “Цензургүй яриа” нэвтрүүлэг, Г.Алтантүрүүгийн “Танайд хоноё” зэрэг нэвтрүүлгийг дууриан хийж болно. Дууриах нь хөгжөөнт наргиантайн дээр бэлтгэхийн тулд сонирхолтой унших судлах тэмүүлэл өрнөж болно. Багаараа хамтран судалгаа хийж болно. Жишээ нь, нэг оюутан Ларри Кингийн намтрыг судалж, нөгөө нь анх ажилд орсон үе, яагаад нэрээ солих болов, автобусанд суун Майамид ирсэн шалтгаан, анхны нэвтрүүлгээ яагаад зоогийн газраас хийснийг сонирхон баримт материал цуглуулж, гурав дахь нь “Ларри Кинг шууд дамжуулж байна” шоуны талаар мэдээлэл бэлтгэн хамтарч ажиллаж болох юм.

Сэтгүүл зүй бол бодит “амьд” үйл явц. Тиймээс сэтгүүл зүйн хичээл заахдаа олны анхаарал татсан, тэдний хүсэн хүлээдэг нэвтрүүлэг, бүтээл, үйл явц, алдартай сэтгүүлчдийн нэвтрүүлгээ хүргэдэг арга маягийг сургалтдаа хэрэглэн хичээл, семинараа сонирхолтой хэлбэрээр

явуулах бүрэн боломжтой. Ийм боломж багш нарт бий.

Монголд хүүхдийн хүссэнээр биш боловсролын хуулийн дагуу дуртай ч бай, дургүй ч бай мэдлэгийг өгөөд байдаг. Яг л саванд ус юүлж байгаа юм шиг. Гэтэл барууны оронд багш лекцийн материалаа оюутан нэг бүртээ урьдчилан тарааж өгөх, эсвэл интернетэд байгаа өөрийн сайтад байрлуулж оюутандаа ашиглах боломжийг нь хангаж өгдөг учраас лекцийн хичээлийг явуулахдаа сурах бичигт “дуу оруулах”-аас татгалзаж, жинхэнэ зөвлөгч, мэдлэгийн менежер, сургалтын үйл

ажиллагааны дасгалжуулагч, боловсролын экспертийн үүднээс идэвхтэй оролцдог болж байна.

Ишлэл

¹ Д.Батжаргал. “Дадлага давамгайлсан сургалтын давуу тал”ЭШӨ. Сэтгүүлч сэтгүүл. 2005. №01.

Резюме

Статья посвящена к вопросу обучения журналистов. Автор предлагает некоторые методы и практические советы которые могут использовать в учебном процессе. В статье отмечается, что исползуя эти методы можно повысить эффективность и результативность семинарских занятия.